



Infinite Solutions, LLC

ULTIMATE

ERP SYSTEM

Infinite Solutions

10-р давхар,
Twin Tower 1,
2-р хороо,
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар,
Монгол улс

(976)-99099766
(976)-99081847
info@infinite.mn
www.infinite.mn





АГУУЛГА

- 02 Танилцуулга
- 03 Модуль
- 05 Статистик
- 07 Онцлог
- 08 Ашиг тус
- 09 Стратегийн түншүүд

**Right data,
Right time,
Right people
by **ULTIMATE****

ТАНИЛЦУУЛГА ULTIMATE ERP СИСТЕМ

ULTIMATE ERP систем нь бизнесийн үйл ажиллагааг удирдан хянах гайхамшигтай боломжийг энгийн хялбар үйлдлүүд, уян хатан ажиллагаа, ухаалаг тайлан мэдээнүүд, оновчтой бүтэц болон ойлгомжтой график диаграммын тусламжтайгаар бий болгоно.

Бизнесийн үйл ажиллагаанд оролцож байгаа хэрэглэгч бүрт тусгайлан зориулсан үйлдлүүд болон бизнес процессуудын тусламжтайгаар өдөр тутмын үйл ажиллагааны талаарх мэдээллийг зохих албан тушаалтнуудад мэдээлэх, анхааруулах боломжтой. Энэ бүхэн нь бизнесийн real-time электрон урсгалыг үүсгэнэ.

Алслагдсан, олон салбартай томоохон компани болон корпорациудын хувьд ч мэдээллийн шинэ үе эхэлж байна гэж хэлж болно. Учир нь ULTIMATE ERP систем алслагдсан хэрэглэгчийг холбохын тулд өртөг хямд, хурд багатай сүлжээний орчинд төвөггүй ажиллах болсон нь олон салбаруудыг онлайн байдлаар холбосон нэгдсэн сүлжээ үүсгэж, улмаар нэгдсэн удирдлагаар хангах, нэгдсэн хяналт тавих боломжийг бий болгож байна.

Мөн B2B (business to business) буюу бизнесээс бизнест гэсэн зарчмыг хэрэгжүүлснээр байгууллага дотооддоо болон байгууллага хооронд электрон байдлаар гэрээ хэлцэл хийх, захиалга борлуулалт боловсруулах, гүйлгээ баримт солилцох, цаг хугацаа хэмнэх, бизнес процессийг автоматжуулах ажлын эхлэлийг тавьж байна. ULTIMATE ERP цогц системд дараах дэд системүүд хамаарагдах ба тэдгээр системүүд өөр хоорондоо бүрэн холбогдож нэгэн цул болж ажиллана.

Үүнд:

1. Санхүү нягтлан бодох бүртгэлийн систем
2. Хүний нөөцийн систем
3. Цаг бүртгэлийн модуль
4. Цалингийн модуль
5. Харилцагчийн удирдлагын систем (CRM)
6. Үндсэн хөрөнгийн систем
7. Худалдан авалтын захиалгын систем
8. Борлуулалтын систем
9. Агуулахын систем
10. Бараа материалын систем
11. Худалдааны менежмент
12. Хүргэлтийн систем
13. Даатгалын систем
14. Ханган нийлүүлэлтийн систем
15. Удирдлагын шинжилгээний систем

ERP системийн нягтлан бодох бүртгэлийн систем нь гол зангилаа систем бөгөөд бусад дэд системүүдтэй нягт уялдан ажилладаг.



МОДУЛЬ ULTIMATE ERP СИСТЕМ



ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖМЕНТ

Гадаад болон дотоодын худалдан авалтын захиалга бүртгэх тэдгээртэй холбоотой дотоод процессуудыг автоматжуулсан, захиалгын автомат санал аюулгүй нөөц дээр үндэслэн боловсруулах боломжтой модуль бөгөөд байгууллагын худалдан авах процессыг хяналт хийх боломжоор хангана.



САНХҮҮГИЙН МЕНЕЖМЕНТ

Санхүүгийн менежмент нь Ерөнхий журналын модуль, Өглөг авлагын модуль зэргээс бүрдэх санхүүгийн гүйлгээ баланс, татвар, санхүүгийн тайлангуудыг гаргах болон ерөнхий удирдлагуудыг дансны мэдээллээр хангана.



БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТ

Гадаад, дотоодын харилцагчийн түүгээлтийн захиалга, тэдгээртэй холбоотой процессуудыг автоматжуулан барааны тасалдал болон худалдан авалтын модультай холбогдон түгээлт хийх процессуудыг автоматжуулсан цогц систем болно.



МӨНГӨН ХӨРӨНГИЙН МЕНЕЖМЕНТ

Мөнгөн хөрөнгийн менежмент нь нийлүүлэгч, борлуулалт, банк санхүүгийн гүйлгээ зэрэг байгууллагын бэлэн мөнгөний бүхий л урсгалыг хянаж дүн шинжилгээ хийх боломжийг олгоно.



ҮНДСЭН ХӨРӨНГИЙН МЕНЕЖМЕНТ

Үндсэн хөрөнгийн менежмент нь аж ахуйн нэгж байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлийг стандартын дагуу хөтлөн явуулах, мэдээллийг богино хугацаанд боловсруулж нэгтгэх болон хэрэглэгчийн бүхий л төвшинд лавлагаа харах, тайлан мэдээ гарган авах боломжийг олгоно.



БАРААНЫ МЕНЕЖМЕНТ

Барааны менежмент нь барааны хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, зорилтот түвшинг тогтоох, нөхөн сэргээх арга техникийг сонгох, барааны зарцуулалтыг хянах, барааны үлдэгдлийг бүртгэх болон барааны статусыг тайлагнах зэрэг БМ-ын бүхий л процессыг багтаасан цогц систем болно.



ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТ

ХНМ нь Хүний нөөцийн модуль, Цаг бүртгэлийн модуль, Цалингийн модуль зэрэг ажилтантай холбоотой гэрээ тушаал, сонгон шалгаруулалт, үнэлэлтийн процессоос эхлээд цаг бүртгэл, цалингийн бодолт хийх цаашлаад цалингийн задаргааг мэйлээр илгээх зэрэг боломжийг олгох цогц систем болно.



ДААТГАЛЫН МЕНЕЖМЕНТ

ДМ нь Даатгалын урсгал, НТ-ын процессуудыг автоматжуулах, тэдгээртэй холбоотой нөөц сангуудын тооцоолол болон СЗХ-ны мэдээг боловсруулж бусад МИЙС зэрэг гадаад програмтай холбогдон ажиллах боломжтой цогц систем болно.



ХУДАЛДААНЫ МЕНЕЖМЕНТ

Худалдааны менежмент нь ПОС, Рестораны ПОС болон худалдааны үнийн бодлого, оноо хөнгөлөлт, бонус болон бусад олон тооны хөтөлбөрүүдийг CRM програмтай хамтран явуулах боломжтой бөгөөд НӨАТУС-тэй холбогдон ажиллах боломжоор хангагдсан систем болно.



ХҮРГЭЛТИЙН МЕНЕЖМЕНТ

Хүргэлтийн менежмент нь үйлчлүүлэгчийн дуудлага бүрийг хөтлөн, хүргэлт хийх процесст хяналт тавьж ажилласнаар цаг хугацааг хэмнэх, борлуулалтыг өсгөх болон үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх боломжийг олгоно.



CRM

CRM нь харилцагчийн цогц мэдээллийн санг үүсгэн бүтээгдэхүүн үйлчилгээ, борлуулалт, худалдан авалтын бонус, оноо хуримтлуулалт, төсөл хөтөлбөрүүд болон гэрээ хэлцлүүд, санал гомдол, уулзалт зэргийг ПОС болон бусад системүүдтэй уялдуулан боловсруулдаг цогц систем болно.




СИСТЕМИЙН МЕНЕЖМЕНТ

Системийн менежмент нь програмд хэрэглэгч ямар үйлдэл хийх эрхийг нарийн тохируулж өгөх ба ингэснээр тухайн байгууллагын мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах боломжийг олгоно.

СТАТИСТИК

Байгууллагын амжилт нь технологийн нөхцөлөөс үл хамааран "бизнесийн процессоо инженерчлэх, процессын соёлыг нутагшуулах" 2 хүчин зүйл юм.



Байгууллага нь менежментийн өөрчлөлтөд хангалттай анхаарал хандуулахад хэцүү байдаг бол ULTIMATE ERP системээр дамжуулан процессуудаа дахин инженерчлэх, шинэ соёлыг нутагшуулах боломжоор бүрэн хангагдана. Дээрх графикаас ULTIMATE ERP системийг ашигласнаар 82% нь бизнесийн гол процессууд, мөн бизнесийн бүх үйл явц, соёлыг өөрчлөх боломжтой.

Байгууллага "менежментийн болон процессын өөрчлөлт өдөр тутмын хэвшмэл болгох" нь амжилтын суурь. ӨӨРЧЛӨЛТ БОЛ ӨДӨР ТУТМЫН ХЭВШМЭЛ ЗҮЙЛ

БИЗНЕС ПРОЦЕССЫН ТОО +250

ӨДӨР БҮР

Аливаа энтерпрайс хэмжээний байгууллагад ӨДӨР БҮР 14% процессын өөрчлөлт хийх шаардлага тулгарч байдаг.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨӨРЧЛӨЛТ




ТЕХНОЛОГИЙН ШИЙДЭЛ



N-Tier технологи ашигласнаар ачаалал даах чадвар +300 дээш, аюулгүй баталгаатай байх боломжтой.


СИСТЕМИЙН УЯЛДАА



ТААРАМЖ

Аливаа байгууллага ULTIMATE ERP систем нэвтрэх таарамжтай байдал

процессуудын таарамжтай байдал



ХАМГААЛАЛТ НУУЦЛАЛТ





ОНЦЛОГ

BUSINESS INTELLIGENCE	BUSINESS ANALYTICS	DASHBOARD	REPORTING
------------------------------	---------------------------	------------------	------------------

CUSTOMER RELATIONSHIP MANAGEMENT	CUSTOMER LOYALTY	CUSTOMER PROMOTION	MARKETING MANAGEMENT
---	-------------------------	---------------------------	-----------------------------

RETAIL MANAGEMENT	PLANOGRAM MODULE	POS MODULE	MERCHANDIZE MODULE	SPACE MANAGEMENT MODULE
--------------------------	-------------------------	-------------------	---------------------------	--------------------------------

FINANCIAL MANAGEMENT	ACCOUNT RECEIVABLE	ACCOUNT PAYABLE	GENERAL LEDGER
-----------------------------	---------------------------	------------------------	-----------------------

HUMAN RESOURCE MANAGEMENT	HUMAN RESOURCE	TIME SHEET	PAYROLL
----------------------------------	-----------------------	-------------------	----------------

MANUFACTURING MANAGEMENT	PRODUCTION BILL OF MATERIALS	SUPPLY PLANNING	PRODUCTION ORDERS	DEMAND FORECASTING
PRODUCTION / PLANNING SCHEDULE				

INVENTORY MANAGEMENT	PLANNING SCHEDULING	PURCHASE MODULE	SALES MODULE	SUPPLY CHAIN MANAGEMENT
WAREHOUSE MANAGEMENT				



АШИГ ТУС



Олон тооны гар ажиллагаатай цаасаар хийгддэг үйлдлүүд үгүй болсноор хамгийн үнэт зүйл болох **ЦАГ** үлэмж хэмнэгдэнэ.



Хүссэн газраасаа холбогдох, real-time ажиллах зэрэг давуу талуудын ачаар хүний хөдөлмөр хөнгөлөгдөж **ХҮНИЙ НӨӨЦ** хэмнэгдэнэ.



Өмнө нь хэд хэдэн хүн хийдэг байсан ажлыг систем автоматаар хийснээр шууд утгаараа **МӨНГӨ** хэмнэгдэнэ.



Удирдлагууд олон шат дамжлагагүйгээр **ГАНЦХАН ТОВЧ** дараад л хүссэн тайлан мэдээгээ нарийвчлалтайгаар авах боломжтой.



Өөрийн гэсэн зөв зохион байгуулалттай өгөгдлийн баазтай болсноор нэмж олон төрлийн тайлан болон мэдээллийн **АНАЛИЗ** хийх боломжтой болно.



Энэ бүгдээс гадна бүх мэдээлэл нэгэн цэгт зангидагдан, нэг системд орсноор байгууллагын хаана юу болж байгааг **ХЯНАХ** боломжтой.

СТРАТЕГИЙН ТҮНШҮҮД

